



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар АМ9

Улаанбаатар хот

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Нийслэлийн Засаг даргын 2026 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/643 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг хавсралт ёсоор олгосугай.

2.Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-г даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газар-ын/ийн дарга-ын/ийн 2026 оны 05 дугаар сарын 12 өдрийн А/19 дугаар тушаалын/ийн хавсралт



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН
ЗЭРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ

2026 оны 05 дугаар сарын 12

Улаанбаатар хот

д/д	Овог, нэр	Албан тушаалын нэр	Албан тушаалын зэрэг дэв	Нэмэгдлийн хувь
1	2	3	4	5
1	Сайндоржийн Туул	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга	Ахлах түшмэл, гутгаар зэрэг	28
2	Батбаатарын Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, дэд зэрэг	22
3	Чулуунбаатарын Энх-Отгон	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, дэд зэрэг	22
4	Батсайханы Халиун	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, гутгаар зэрэг	20
5	Батдэлгэрийн Энхцэцэг	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, гутгаар зэрэг	20